



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 5/50

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2026 оны 02/8833 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэлээжавын Батболд нь Хавдар судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн даргаар өөрийгөө томилсон шийдвэр гаргахдаа холбогдох хуульд зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тул албан тушаалын цалингийн хэмжээг 02 сараар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны системд сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг оруулахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн албанд даалгасугай.

3. Ц.Батболдод Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргийг хангаж, мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д даалгасугай.

САЙД

Э.БАТШУГАР

141261001